

Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын  
2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн  
А/139 дүгээр тушаалын хавсралт

## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ НЭГТГЭЛ, АНГИ, БАЙГУУЛЛАГАД НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нээлттэй өдөрлөгийг Төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагууд харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулна.

1.2. Нээлттэй өдөрлөгийг зохион байгуулах, дүнг мэдээлэх ажлыг Зэвсэгт хүчний Жанжин штабын Зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдэд ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын орлогч даргаар, Төрлийн цэргийн командлалуудад командлалын штабын даргаар, нэгтгэл, анги, байгууллагуудад захирагчийн нэгдүгээр орлогч, штабын даргаар тус тус ахлуулсан ажлын хэсэг зохион байгуулна. Ажлын хэсэг бүрийг ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, Төрлийн цэргийн командлагч, нэгтгэл, анги, байгууллагын захирагч /дарга/-ийн шийдвэрээр томилно

1.3. ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, Төрлийн цэргийн командлагч, нэгтгэл, анги, байгууллагын захирагч /дарга/ нар нээлттэй өдөрлөгийг зохион байгуулах чиглэлээр тодорхой удирдамж, төлөвлөгөө гарган ажиллана.

1.4. Нээлттэй өдөрлөгийн үеэр батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, Төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, байгууллагын бүтээлч ажил, арга хэмжээ, тэдгээрийн нийгэм, эдийн засаг, улс орны хөгжилд үзүүлж буй эерэг үр дүн, нөлөөг цэргийн алба хаагчдын гэр бүл, иргэд, хүүхэд залуучуудад сурталчлан таниулах, мэдээлэх ажлыг хэрэгжүүлнэ.

1.5. Нээлттэй өдөрлөгт оролцогсдыг нэгтгэл, анги, байгууллагын байнгын байрлалд нэвтрүүлэх арга хэмжээг “Цэргийн дотоод албаны дүрэм”-ийн 200-203 дугаар зүйлийг баримтлан хэрэгжүүлнэ.

1.6. Төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, хэвлэл мэдээллийн сэтгүүлч, сурвалжлагч нартай хамтран ажиллаж болно.

1.7. Нээлттэй өдөрлөгийг зохион байгуулах үед Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.11, 5.1.12 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсэг, Зэвсэгт хүчний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.20 дахь заалтуудыг баримтлан ажиллана.

1.8. Нээлттэй өдөрлөгийг зохион байгуулсан дүн, иргэдээс ирүүлсэн санал, хүсэлтийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг “зохиосон ажил, арга хэмжээ, оролцсон бүрэлдэхүүн, үр дүн, санал хүсэлт” гэсэн бүтэцтэйгээр боловсруулж, гэрэл зургаар баримтжуулан тухайн арга хэмжээ дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор ЗХЖШ, Төрлийн цэргийн командлалын холбогдох газар, хэлтэст хүргүүлнэ.

Хоёр. Нээлттэй өдөрлөгийн ажил, арга хэмжээ

2.1. Нээлттэй өдөрлөгөөр дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлнэ:

2.1.1. батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, бүтээлч ажил, арга хэмжээний үр дүнгийн танилцуулга;

2.1.2. төрлийн цэргийн командлалын танилцуулга;

2.1.3. Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын танилцуулга, мэдээлэл;

2.1.4. байнгын байрлал дахь цэргийн байр, гал тогоо, хичээлийн танхим, номын сан, соёлын төв, дайчин алдрын танхим, спортын заалаар оруулах, анги, салбарын өдөр тутмын үйл ажиллагаатай танилцуулах;

2.1.5. иргэдийн санал, зөвлөгөөг сонсох, нэгтгэл, анги, байгууллагын захирагч /дарга/ нар өөрийн эрх мэдлийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх, бүтээлч ажил хэрэгч саналыг дээд байгууллагад уламжлах;

2.1.6. цэргийн хэргийн үзүүлэх болон урлагийн тоглолтыг толилуульж, зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслийг дэлгэн үзүүлэх.

#### Гурав. Нээлттэй өдөрлөгийн үеийн албан тушаалтны үүрэг

3.1. Нэгтгэл, анги, байгууллагын захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга “Цэргийн дотоод албаны дүрэм”-ийн 71.1, 71.2, 71.4, 71.7, 73.5, 73.15 дахь зүйлээр хүлээсэн үүргийг биелүүлж, ахлах даргын өгсөн үүрэг, ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавина.

3.2. Нэгтгэл, анги, байгууллагын захирагчийн орлогч нь “Цэргийн дотоод албаны дүрэм”-ийн 71.1, 71.2, 71.4, 71.7, 74.6, 74.7 дахь зүйлээр хүлээсэн үүрэг, ахлах даргын өгсөн үүргийг цаг тухайд нь биелүүлэн ажиллана.

3.3. Төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, байгууллагын сэтгэл зүйн хангалт хариуцсан нэгж, албан тушаалтан “Цэргийн дотоод албаны дүрэм”-ийн 71.1, 71.2, 71.4, 71.7, 96.3, 96.7, 97.2, 97.4 дэх зүйл, “Сэтгэл зүйн хангалтыг зохион байгуулах заавар /тайван цагт/-ын 1.2.4 дэх заалт, 1.3, 4.5, 5.5 дахь зүйлүүдийг тусгайлан баримтлан, албан тушаалын тодорхойлолтод заагдсан үүргээ биелүүлэн ажиллана.

3.4. Төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, хэвлэл мэдээллийн сэтгүүлч, сурвалжлагч нар нэгтгэл, анги, байгууллагын байнгын байрлалд нэвтэрсэн үедээ тухайн байгууллагын дотоод журмыг хүндэтгэн, албан тушаалтны тавьсан шаардлагыг биелүүлнэ.

#### Дөрөв. Нээлттэй өдөрлөгийг явуулах нөхцөл

4.1. Нээлттэй өдөрлөгийг дараах нөхцөлд зохион байгуулж болно:

4.1.1. “Монгол цэргийн өдөр”, Зэвсэгт хүчний ойн баярыг тэмдэглэх;

4.1.2. энхийг сахиулагчдын өдөр;

4.1.3. монгол бахархалын өдөр;

4.1.4. олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр;

4.1.5. олон улсын гэр бүлийн өдөр;

4.1.6. нээлттэй хаалганы өдөр;

4.1.7. цэргийн тангараг өргөх;

4.1.8. нэгтгэл, анги, байгууллагын түүхт ойг тэмдэглэх.

#### ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ